# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр Дугаар 253 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 29,543,600.00 (хорин есөн сая таван зуун дөчин гурван мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, 14,443,538.42 (арван дөрвөн сая дөрвөн зуун дөчин гурван мянга таван зуун гучин найман төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Алтанзаяа, Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Ц.Сонгууль нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

0001905

D:\Huraldaanii material\2018 on\2018.06.05\11docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын .05-ны өдрийн
253. дүгээр тогтоолын хавсралт

## "Харгуй" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас Налайх дахь мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он | Тоо ширхэг | нийт гүйлт | Балансын дүн (төгрөгөөр) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Үлдэгдэл өртөг (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёота Ланд круйзер-80 маркийн, 60-37 ХЭА улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар-HDJ810070008 | 1996/2008 | 1 | 189900 | 29,543,600.00 | 14,443,538.42 | 15,100,061.58 |
| | | | 1 | | 29,543,600.00 | 14,443,538.42 | 15,100,061.58 |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1 (нэг)** | | **29,543,600.00 (хорин есөн сая таван зуун дөчин гурван мянга зургаан зуун)** | **14,443,538.42 (арван дөрвөн сая дөрвөн зуун дөчин гурван мянга таван зуун гучин найман төгрөг дөчин хоёр мөнгө)** | **15,100,061.58 (арван таван сая нэг зуун мянга жаран нэгэн төгрөг тавин найман мөнгө)** |